

I-V/2021


Тархаасан: 2021 оны 6 дугаар сарын 14



Цагаан ноолуурын 1 кг-ын үнэ Баянхонгор аймагт хамгийн их буюу 130.0 мянган төгрөг байна


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 5 дугаар сард атны 1.2 сая төгрөг, хязаалан гуны үнэ 1.1 сая төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй, соёолон үрээний үнэ 1.0 сая төгрөг болж, өмнөх сараас 59.6 мянган төгрөгөөр өссөн байна. Харин эр хонины үнэ 218.6 мянган төгрөг болж, өмнөх сараас 24.1 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 144.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 12.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 1. Нас гүйцсэн малын дундаж үнэ, 5 дугаар сард, мянган төгрөгөөр




Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 5 дугаар сард эр хонь Улаанбаатар хотод хамгийн их буюу 270.0 мянган төгрөг болж өмнөх сараас 60.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, Дорнод аймагт хамгийн бага буюу 143.2 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Зураг 2. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ, 2021 оны 5 дугаар сард, мянган төгрөгөөр




Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 5 дугаар сард цагаан ноолуурын 1-кг-ын дундаж үнэ Баянхонгор аймагт хамгийн их буюу 130.0 мянган төгрөг, Дорнод, Хэнтий аймагт хамгийн бага буюу тус бүр 80.0 мянган төгрөг байна.

Зураг 2. Цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ, 2021 оны 5 дугаар сар, төгрөгөөр



Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 5 дугаар сард үхрийн 2 метрээс дээш урттай шир 7.7 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 107.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Зураг 3. Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 5 дугаар сард, төгрөг



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 5 дугаар сард 25кг хивгийн үнэ Завхан, Орхон аймагт хамгийн их буюу 24.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.0 мянган төгрөгөөр, Архангай аймагт хамгийн бага буюу 11.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 9.5 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

Эх үүсвэр: ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ



Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 7 дугаар сарын 19

*Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн
газрын Гэрээт ажилтан Б. Оргил
Утас : (976-51)-261561*

